

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20....оны....сарын....өдөр

Улаанбаатар хот

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, тэтгэврийн төрлийг тодорхойлох, тэтгэвэр тогтоох, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

2.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.“тэтгэвэр” гэж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4.1.7-д заасныг;

2.1.2.“суурь тэтгэвэр” гэж тэтгэвэр авагчийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор сар бүр олгох мөнгөн хөрөнгийг;

2.1.3.“тэтгэвэр бодох нэрийн дансны арга” гэж даатгуулагчийн нэрийн дансанд бүртгэсэн нийт орлого, тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэлд үндэслэн сард олгох тэтгэврийн хэмжээг тооцохыг;

2.1.4.“тэтгэвэр бодох цалинд үндэслэсэн арга” гэж даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаа, сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээнд үндэслэн сард олгох тэтгэврийн хэмжээг тооцохыг;

2.1.5.“тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл” гэж даатгуулагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрснээс хойш тэтгэвэр авах дундаж хугацааг;

2.1.6.“цэргийн алба хаасан хугацаа” гэж Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасныг.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ТЭТГЭВРИЙН ТОГТОЛЦОО**

### **3 дугаар зүйл.Олон давхаргат тэтгэврийн тогтолцоо**

3.1.Монгол Улс нь олон давхаргат тэтгэврийн тогтолцоотой байна. Олон давхаргат тэтгэврийн тогтолцоо нь дараах давхаргын тэтгэврээс бүрдэнэ:

- 3.1.1.нэгдүгээр давхарга буюу суурь тэтгэвэр;
- 3.1.2.хоёрдугаар давхарга буюу тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр;
- 3.1.3.гуравдугаар давхарга буюу хувийн нэмэлт тэтгэвэр.

3.2.Суурь тэтгэврийн зардлыг улсын төсөв, газрын хэвлийн баялгийн үр өгөөжөөс санхүүжүүлнэ.

3.3.Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн зардлыг тэтгэврийн даатгалын сан, улсын төсвөөс санхүүжүүлнэ.

3.4.Хувийн нэмэлт тэтгэврийн харилцааг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиар зохицуулна.

### **4 дүгээр зүйл.Суурь тэтгэвэр**

4.1.Энэ хуулийн 7.1.1-д заасан насанд хүрсэн тэтгэвэр авагч суурь тэтгэвэр авах эрхтэй.

4.2.Суурь тэтгэврийн хэмжээг Засгийн газраас тухай бүр тогтооно.

4.3.Суурь тэтгэврийг энэ хуулийн 7.1.1-д заасан насанд хүрсэн өдрөөс эхлэн нас барсны дараагийн сарыг дуустал олгоно.

### **5 дугаар зүйл.Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр**

5.1.Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр дараах төрөлтэй байна:

- 5.1.1.өндөр насны;
- 5.1.2.хөдөлмөрийн чадвар алдсаны;
- 5.1.3.тэжээгчээ алдсаны.

### **6 дугаар зүйл.Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээ**

6.1.Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээг доор дурдсанаар Засгийн газар тогтооно:

6.1.1.энэ хуулийн 7.1, 12.1, 17.1-д заасны дагуу тэтгэвэр тогтоолгон авах эрх үүссэн даатгуулагч, иргэний тэтгэврийн доод хэмжээ нь тухайн үед мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байхаар;

6.1.2.энэ хуулийн 7.2, 12.2, 17.2-т заасны дагуу тэтгэвэр тогтоолгон авах эрх үүссэн даатгуулагч, иргэний тэтгэврийн доод хэмжээ нь тухайн үед мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас багагүй байхаар.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР**

### **7 дугаар зүйл.Өндөр насны тэтгэвэр авах эрх**

7.1.Доор дурдсан даатгуулагч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй:

7.1.1.тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-оос доошгүй жил төлсөн өндөр насны тэтгэврийн ердийн насанд хүрсэн даатгуулагч;

7.1.2.тэтгэврийн даатгалын шимтгэлийг 25-аас доошгүй жил төлсөн 60 насанд хүрсэн эрэгтэй, 55 насанд хүрсэн эмэгтэй;

7.1.3.төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв ба түүнээс дээш хүүхдээ зургаан нас хүртэл өсгөсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-оос доошгүй жил төлсөн 50 насанд хүрсэн эмэгтэй;

7.1.4.нийтдээ 20-оос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 55 насанд хүрсэн эрэгтэй, нийтдээ 20-оос доошгүй жил, үүнээс 7 жил 6 сараас доошгүй жил мөн нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 50 насанд хүрсэн эмэгтэй;

7.1.5.нийтдээ 20-оос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй жил хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 55 насанд хүрсэн эрэгтэй, түүнчлэн нийтдээ 20-оос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил мөн нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 50 насанд хүрсэн эмэгтэй;

7.1.6.нийтдээ 20-оос доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 55 насанд хүрсэн эрэгтэй, нийтдээ 20-оос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 50 насанд хүрсэн эмэгтэй;

7.1.7.сонгодог, мэргэжлийн урлагийн байгууллагад гоцлол дуучин, бүжигчин, агаарын болон хэрэглэлийн гимнастик, акробат, тэнцвэр, уран нугаралт, хүнд жингийн үзүүлбэрийн жүжигчин, зэрлэг араатан, ан амьтан сургаж тоглуулагч, хөөмийчин, найрал хөгжмийн үлээвэр хөгжимчнөөр 20-оос доошгүй жил ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, эсхүл нийтдээ 25-аас доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил мөн мэргэжлээр ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн

даатгуулагч.

7.2.Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 15-20 хүртэл жил төлсөн энэ зүйлийн 7.1.1-д заасан насанд хүрсэн даатгуулагч өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгон авах эрхтэй.

7.3.Газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт, хэрэглэх журмыг хөдөлмөр, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Тайлбар: Энэ хэсгийн 7.1.1-д заасан өндөр насны тэтгэврийн ердийн нас нь 1957 он ба түүнээс өмнө төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 60, 1962 он ба түүнээс өмнө төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 55 байна. Цаашид 1958 онд төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 60 нас 3 сар, 1963 онд төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 55 нас 3 сар байх бөгөөд тэтгэвэр тогтоолгох насыг даатгуулагчийн төрсөн онд харгалзуулан 3 сараар нэмэгдүүлж, 1977 он ба түүнээс хойш төрсөн эрэгтэй, 2002 он ба түүнээс хойш төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 65 байна. Тухайн жилд тэтгэвэр тогтоолгох насыг өндөр насны тэтгэврийн ердийн нас гэнэ.

- Энэ хэсгийн 7.1.2-т заасан тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа 2023 онд 21 жил 6 сар байх бөгөөд энэ хугацааг 25 жил хүртэл жил бүр 3 сараар нэмэгдүүлнэ.

- Энэ хэсгийн 7.2-т заасан тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа 2023 онд 10 жил байх бөгөөд энэ хугацааг 15 жил хүртэл жил бүр 3 сараар нэмэгдүүлнэ.

- Энэ хэсгийн 7.1.4-т заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас 1973 он ба түүнээс өмнө төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 50, 1978 он ба түүнээс өмнө төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 45 байна. Цаашид 1974 онд төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд 50 нас 3 сар, 1979 онд төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд 45 нас 3 сар байх бөгөөд тэтгэвэр тогтоолгох насыг даатгуулагчийн төрсөн онд харгалзуулан 3 сараар нэмэгдүүлж, 1993 он ба түүнээс хойш төрсөн эрэгтэй даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 55, 1998 он ба түүнээс хойш төрсөн эмэгтэй даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийн нас 50 байна.

## **8 дугаар зүйл.Өндөр насны тэтгэвэр бодох арга**

8.1.Өндөр насны тэтгэврийг дараах аргаар бодно:

8.1.1.даатгуулагч 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө төрсөн бол тэтгэвэр бодох цалинд үндэслэсэн (цаашид “цалинд үндэслэсэн” гэх) аргаар;

8.1.2.даатгуулагч 1979 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн бол тэтгэвэр бодох нэрийн данс (цаашид “нэрийн данс” гэх)-ны аргаар.

8.2. Даатгуулагч 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 1979 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл хугацаанд төрсөн бол энэ зүйлийн 8.1-д заасан аргаас зөвхөн нэг удаа өөрөө сонгоно.

8.3. Энэ хуулийн 7.1.3-7.1.7-д заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрх үүссэн 1979 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагч цалинд үндэслэсэн аргыг сонгож болно.

## **9 дүгээр зүйл. Өндөр насны тэтгэврийг цалинд үндэслэсэн аргаар бодох**

9.1. Даатгуулагчийн өндөр насны сарын тэтгэврийг цалинд үндэслэсэн аргаар бодоход дараах томъёог хэрэглэнэ:

$$T_{\text{ц}} = \text{Ц} \times 2\% \times \text{Ш}_{\text{с}} / 12$$

$T_{\text{ц}}$ -цалинд үндэслэсэн аргаар тооцсон сарын тэтгэврийн хэмжээ;  
 $\text{Ц}$ -энэ зүйлийн 9.7-д заасны дагуу тооцсон сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого;  
 $\text{Ш}_{\text{с}}$ -шимтгэл төлсөн нийт сар.

Тайлбар: Өндөр насны тэтгэврийг цалинд үндэслэсэн аргаар бодохдоо шимтгэл төлсөн жил тутамд 2.0 хувиар, сар тутамд 1.667 хувиар тооцно.

9.2. Энэ хуулийн 7.1.1-д заасан наснаас хойш тэтгэвэр тогтоолгох бол тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр ( $T_{\text{ц}}$ )-ийн хэмжээг тэтгэвэр тогтоолгоогүй жил бүрт 4 хувиар нэмэгдүүлэн тооцно.

9.3. Энэ хуулийн 7.1.2-т заасны дагуу тэтгэвэр тогтоолгох бол тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр ( $T_{\text{ц}}$ )-ийн хэмжээг энэ хуулийн 7.1.1-д заасан насанд хүртэлх жил бүрт 4 хувиар бууруулан тооцно.

9.4. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд 1 хувиар бодож нэмэгдүүлнэ.

9.5. Тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш 12 сараас доошгүй хугацаанд хөдөлмөр эрхэлж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол анх тэтгэвэр тогтоолгосон сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 12 сар тутамд 2.0 хувиар, сар тутамд 1.667 хувиар тооцон тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.

9.6. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан байвал зохих сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос бодно.

Тайлбар: Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дараалсан байвал зохих сар (цаашид “дараалсан байвал зохих сар” гэх) 2023 онд 84 сар байх бөгөөд энэ сарын тоог 120 сар хүртэл жил бүр 3 сараар нэмэгдүүлнэ.

9.7.Өндөр насны тэтгэвэр тогтоолгох сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого (Ц)-ыг дараах байдлаар тооцно:

9.7.1.дараалсан байвал зохих сар бүр шимтгэл төлсөн бол мөн хугацааны хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг дараалсан байвал зохих сарын тоонд хуваана;

9.7.2.дараалсан байвал зохих сард 5 ба түүнээс бага сар шимтгэл төлөөгүй бол уг дараалсан шимтгэл төлсөн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг мөн шимтгэл төлсөн сарын тоонд хуваана;

9.7.3.дараалсан байвал зохих сард 5-аас их сар шимтгэл төлөөгүй бол уг дараалсан шимтгэл төлсөн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг дараалсан байвал зохих сарын тооноос 5-ыг хасаж тооцсон сарын тоонд хуваана.

9.8.Тэтгэвэр тогтоолгох дараалсан байвал зохих хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджийг тодорхойлох, хэрэглэх журмыг нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

9.9.Даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох 1995 оноос өмнөх хугацааны хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь архивын, эсхүл санхүүгийн баримтаар нотлогдох боломжгүй тохиолдолд тэтгэврийн хэмжээг үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалинг баримтлан бодно.

9.10.Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалинг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан хөдөлмөр, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **10 дугаар зүйл.Өндөр насны тэтгэврийг нэрийн дансны аргаар бодох**

10.1.Даатгуулагчийн өндөр насны сарын тэтгэврийг нэрийн дансны аргаар бодоход дараах томъёог хэрэглэнэ:

$$T_{нд} = НД_{C2} / 12K$$

$T_{нд}$ -нэрийн дансны аргаар тооцсон сарын тэтгэврийн хэмжээ;

$НД_{C2}$ -Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 28.9-д заасны дагуу тооцсон нэрийн дансны тухайн жилийн эцсийн үлдэгдэл;

$K$ -тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл.

10.2.Тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш 12 сарын хугацаанд хөдөлмөр эрхэлж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн тохиолдолд уг хугацаанд

бүртгэгдсэн нэрийн дансны нийт орлогыг тэтгэвэр авсан хугацаанаас хойш тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэлд хувааж тооцсон дүнгээс сард ногдох хэмжээгээр тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.

10.3.Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Үндэсний статистикийн хороо, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тус тус үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл жил бүр тогтооно.

### **11 дүгээр зүйл.Өндөр насны тэтгэвэр олгох хугацаа**

11.1.Өндөр насны тэтгэврийг даатгуулагч өргөдлөө тэтгэвэр тогтоолгох насанд хүрэхээс өмнө гаргасан бол уг насанд хүрсэн өдрөөс, хэрэв тэтгэвэр тогтоолгох насанд хүрснээс хойш гаргасан бол өргөдлийг нийгмийн даатгалын байгууллага /байцаагч/ хүлээн авсан өдрөөс эхлэн нас барсны дараагийн сарыг дуустал олгоно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ ТЭТГЭВЭР**

### **12 дугаар зүйл.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авах эрх**

12.1.Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-оос доошгүй жил, эсхүл хөдөлмөрийн чадвараа алдахын өмнөх сүүлийн 5 жилд нийтдээ 36 ба түүнээс дээш сар төлсөн даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

12.2.Тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн чадвараа алдахаас өмнө нийтдээ 36 ба түүнээс дээш сар төлсөн даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгон авах эрхтэй.

12.3.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байсан даатгуулагч хөдөлмөрийн чадвараа нөхөн сэргээгдсэнээс хойш 6 сарын дотор дахин хөдөлмөрийн чадвараа алдсан бол өмнө нь хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгоход баримталсан хөдөлмөрийн хөлсний хэмжээ, шимтгэл төлсөн хугацааг үндэслэн тэтгэврээ тогтоолгон авч болно.

### **13 дугаар зүйл.Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох**

13.1.Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг эрүүл мэндийн магадлалын зөвлөл тогтооно.

13.2.Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар зохицуулна.

## **14 дүгээр зүйл.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг бодох арга**

14.1.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг бодоход дараах томъёогоор хэрэглэнэ:

$$T_{\text{хча}}=[(\text{Ц} \times 40\%)+(\text{Ш}_c /240 \times \text{Ц} \times 0.1)] \times \text{ХЧА}\%$$

$T_{\text{хча}}$ -хөдөлмөрийн чадвар алдсаны сарын тэтгэврийн хэмжээ;

Ц-энэ зүйлийн 14.2-т заасны дагуу тооцсон сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого;

$\text{Ш}_c$ -даатгуулагчийн шимтгэл төлсөн сарын тоо;

ХЧА%-даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь.

14.2.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр бодох сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого /Ц/-ыг дараах байдлаар тооцно:

14.2.1.тэтгэврийн даатгалын шимтгэлийг 60 ба түүнээс дээш сар төлсөн бол даатгуулагчийн сонгосон дараалсан 60 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг уг сарын тоонд хуваана;

14.2.2.тэтгэврийн даатгалын шимтгэлийг дараалсан 60 хүртэлх сар төлсөн бол түүний шимтгэл төлсөн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг шимтгэл төлсөн нийт сарын тоонд хуваана.

## **15 дугаар зүйл.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр олгох хугацаа**

15.1.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, хэрэв тэтгэвэр авагч нас барсан бол нас барсны дараагийн сарыг дуустал олгоно.

## **16 дугаар зүйл.Хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн тогтоож, тэтгэврийг нөхөн олгох**

16.1.Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоосон хугацаа нь дууссанаас хойш хүндэтгэн үзэх шалтгаанаар тэтгэвэр авагч 6 сарын дотор хөдөлмөрийн чадвараа алдсан хувь, хугацаагаа нөхөн сунгуулсан бол түүний 2 хүртэлх сарын тэтгэврийг нөхөн олгоно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ТЭТГЭВЭР**

### **17 дугаар зүйл.Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх**

17.1.Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-оос доошгүй жил, эсхүл нас барахын өмнөх сүүлийн 5 жилд нийтдээ 36 ба түүнээс дээш сар төлсөн даатгуулагч, эсхүл

өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч нас барсан бол түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй дараах гишүүн тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй:

17.1.1.төрсөн, дагавар, үрчлэн авсан 19 нас хүрээгүй хүүхэд; /үүнд эцгээ нас барснаас хойш мэндэлсэн, төрсөн хүүхэд хамаарна/

17.1.2.тэжээгчийн асрамжид байсан төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл 19 нас хүрээгүй байхдаа хөгжлийн бэрхшээлтэй болсон төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд;

17.1.3.тэжээгчийн хууль ёсоор асран хамгаалж, харгалзан дэмжиж байсан төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл 19 нас хүрээгүй байхдаа хөгжлийн бэрхшээлтэй болсон ач, зээ;

17.1.4.тэжээгчийг нас барахын өмнө энэ хуулийн 7.1.1-д заасан насанд хүрсэн, эсхүл хөдөлмөрийн чадвараа 50-аас доошгүй хувиар алдаж хөгжлийн бэрхшээлтэй болсон эхнэр, нөхөр, тэжээн тэтгэх өөр хүнгүй эцэг, эх;

17.2.Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 60-аас доошгүй сар, үүнээс 12 сар нь тасралтгүй төлсөн даатгуулагч нас барсан бол түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүн тэжээгчээ алдсаны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгон авах эрхтэй.

## **18 дугаар зүйл.Тэжээгчээ алдсаны тэтгэврийг бодох арга**

18.1.Тэжээгчээ алдсаны сарын тэтгэврийг бодоход дараах томъёогоор хэрэглэнэ:

$$T_{\text{та}}=[(Ц \times 40\%)+(Ш_{\text{с}}/240 \times Ц \times 0.1)] \times \Gamma_{\text{хувь}}$$

$T_{\text{та}}$ -тэжээгчээ алдсаны сарын тэтгэврийн хэмжээ;

$Ц$ -энэ зүйлийн 18.2-т заасны дагуу тооцсон сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого;

$Ш_{\text{с}}$ -даатгуулагчийн шимтгэл төлсөн сарын тоо;

$\Gamma_{\text{хувь}}$ -гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тооноос хамааруулан энэ зүйлийн 18.3-т заасан хувь хэмжээ.

18.2.Сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого / $Ц$ -ыг энэ хуулийн 14.2-т заасны дагуу тооцно.

18.3.Тэжээгчээ алдсаны тэтгэврийг нас барсан даатгуулагчийн асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тооноос хамааруулан дараах хувь хэмжээгээр тогтооно:

Хөдөлмөрийн чадваргүй гишүүний тоо	Тэтгэвэр бодох хувь хэмжээ (Г <sub>хувь</sub> )
3 ба түүнээс дээш	100
2	75
1	50

18.4.Гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүний 2 тэжээгч нь нас барсан тохиолдолд тэжээгчээ алдсаны тэтгэврийг тэдгээрийн авч байсан сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрээс тооцсон дундаж хөдөлмөрийн хөлснөөс энэ зүйлийн 18.3-т заасан хувь хэмжээгээр бодно.

18.5.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байсан тэжээгч нас барсан бол тэжээгчээ алдсаны тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд нь 1 хувиар бодож нэмэгдүүлнэ.

### **19 дүгээр зүйл.Тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох хугацаа, нөхөн олгох**

19.1.Тэжээгчээ алдсаны тэтгэврийг хүүхдэд 19 нас хүртэл, хөдөлмөрийн чадвараа алдсан иргэнд хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, энэ хуулийн 7.1.1-д заасан насанд хүрсэн иргэнд нас барсны дараагийн сарыг дуустал тус тус олгоно.

19.2.Тэжээгчийг сураггүй алга болсныг нь тогтоож, нас барснаар тооцсон шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд 60 хүртэлх сарын тэтгэврийг нөхөн олгоно.

### **20 дугаар зүйл.Тэжээгчээ алдсаны тэтгэврийг нэгтгэн тогтоох**

20.1.Тэжээгчээ алдсаны тэтгэврийг тэжээгчийн асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй бүх гишүүнд нэгтгэн нэг тэтгэвэр тогтооно.

20.2.Энэ зүйлийн 20.1-д заасны дагуу тогтоосон тэтгэврийг тэжээгчийн асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүний хүсэлтээр гишүүн бүрт тэнцүү хэмжээгээр хуваан олгож болно.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ТЭТГЭВЭР ТОГТООХ, ОЛГОХ**

### **21 дүгээр зүйл.Тэтгэвэр тогтоох**

21.1.Даатгуулагчид энэ хуульд заасан тэтгэврийг нийгмийн даатгалын байгууллага /байцаагч/ тогтооно.

21.2.Цалинд үндэслэсэн аргаар өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоохдоо даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй

адилтгах орлогод Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 22.2-т заасны дагуу тогтоосон итгэлцүүр хэрэглэнэ.

## **22 дугаар зүйл.Тэтгэвэр тогтоолгох өргөдөл гаргах, шийдвэрлэх хугацаа**

22.1.Тэтгэвэр тогтоолгох өргөдлийг энэ зүйлийн 22.2-т заасан журмын дагуу бүрдүүлсэн баримт бичгийн хамт дараах хугацаанд нийгмийн даатгалын байгууллага /байцаагч/-д цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргана:

22.1.1.өндөр насны тэтгэврийг тэтгэвэр тогтоолгон авахыг хүссэн хугацаанд;

22.1.2.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг хөдөлмөрийн чадвар алдсан хувь тогтоолгосноос хойш 14 хоногийн, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 3 сарын дотор;

22.1.3.тэжээгчээ алдсаны тэтгэврийг тэжээгч нь нас барснаас хойш 30 хоногийн, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор.

22.2.Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр олгохтой холбоотой бусад харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална.

22.3.Нийгмийн даатгалын байгууллага /байцаагч/ нь даатгуулагч, эсхүл даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэтгэвэр тогтоох асуудлыг түүний тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор шийдвэрлэнэ.

22.4.Тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтын загвар, тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам, тэтгэвэр бодох аргачлал, зааврыг нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

## **23 дугаар зүйл.Тэтгэвэр олгох**

23.1.Нийгмийн даатгалын байгууллага энэ хуулийн 4, 5 дугаар зүйлд заасан тэтгэврийг тэтгэвэр авагчийн сонгосон арилжааны банкаар дамжуулан сар бүр олгоно.

23.2.Өндөр насалсан болон хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тэтгэврээ өөрийн биеэр авах боломжгүй тэтгэвэр авагчийн тэтгэврийг түүний итгэмжилсэн төлөөлөгчид, тэтгэвэр авагч иргэн эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон, чадамж хязгаарлагдсан бол асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгож болно.

23.3.Арван дөрөв ба түүнээс доош насны хүүхдийн тэжээгчээ алдсаны тэтгэврийг түүний хууль ёсны төлөөлөгчид олгоно.

23.4.Тэтгэвэр авагчийн нас барсны дараагийн сарын тэтгэврийг тэтгэвэр авагчийн гэр бүлийн гишүүнд нийгмийн даатгалын байгууллагаас олгосон мэдэгдэлд үндэслэн банкаар дамжуулан олгоно.

23.5.Даатгуулагч энэ хуулийн 22.1-д заасан хугацаанаас хойш тэтгэвэр тогтоолгох өргөдөл гаргаж, холбогдох баримт бичгийг бүрэн бүрдүүлсэн бол нийгмийн даатгалын байгууллага /байцаагч/ өргөдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн тэтгэвэр тогтооно.

## **24 дүгээр зүйл.Тэтгэвэр олголтыг түдгэлзүүлэх, зогсоох, сэргээх**

24.1.Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоосон хугацаа нь дууссанаас хойш тэтгэвэр авагч 14 хоногийн дотор хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгуулаагүй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хамтарсан болон дахин магадлал, эрх бүхий байгууллагын хяналт шалгалтад хамрагдахаас зайлсхийсэн тохиолдолд тэтгэвэр олголтыг түдгэлзүүлнэ.

24.2.Тэтгэвэр олголтыг дараах үндэслэлээр зогсооно:

24.2.1.хуурамч баримт бичиг бүрдүүлж тэтгэвэр авсан бол нийгмийн даатгалын болон мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн актад заасан хугацаанаас;

24.2.2.тэтгэвэр авагчийг нас барсны дараагийн сарыг дууссан өдрөөс, эсхүл тэтгэвэр авагч сураггүй алга болсныг тогтоож, нас барснаар тооцсон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс;

24.2.3.тэтгэвэр авагч Монгол Улсын харьяатаас гарсан тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг хүчин төгөлдөр болсон өдрөөс;

24.2.4.Монгол Улсын нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Монгол Улсад байнга оршин суугаа тэтгэвэр авагч гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хилээр гарсан өдрөөс;

24.2.5.тэтгэвэр авагч өөр төрлийн тэтгэврийг сонгосон тохиолдолд шинээр тогтоолгосон тэтгэврийг олгож эхэлсэн өдрөөс.

24.3.Зогсоосон тэтгэврийг дараах тохиолдолд сэргээж олгоно:

24.3.1.тэтгэвэр тогтоолгосон нөхцөл зөв болох нь нотлогдсон бол холбогдох баримт бичгийг бүрэн бүрдүүлж, өргөдөл хүлээн авсан өдрөөс;

24.3.2.тэтгэвэр авагчийг сураггүй алга болсныг нь тогтоож, нас барснаар тооцсон шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон шийдвэр гарсан өдрөөс.

24.4.Энэ зүйлийн 24.3.2-г заасан шийдвэрийг үндэслэн тэтгэвэр олголтыг сэргээсэн тохиолдолд 60-аас ихгүй сарын тэтгэврийг нөхөн олгоно.

## **25 дугаар зүйл.Тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтоох**

25.1.Тэтгэврийн хэмжээг дараах тохиолдолд өөрчлөн тогтооно:

25.1.1.тэтгэврийг нь тогтооход баримталсан шимтгэл төлсөн хугацаа болон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, төлсөн шимтгэлийн хэмжээ өөрчлөгдөх үндэслэлтэй бол;

25.1.2.хөдөлмөрийн чадвар алдалтын хувьд өөрчлөлт орсон бол;

25.1.3.нас барсан тэжээгчийн асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүний тоонд өөрчлөлт орсон бол;

25.1.4.тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш 12 сараас доошгүй хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол;

25.1.5.тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байсан 19 нас хүрээгүй хүүхдэд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоогдох эрх дахин үүссэн бол.

25.2.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн бол тогтоосон өндөр насны тэтгэврийн хэмжээ нь өмнө авч байсан хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн хэмжээнээс багагүй байна.

25.3.Тэтгэвэр авагч нь энэ зүйлийн 25.1.2, 25.1.3-т заасан өөрчлөлтийг нийгмийн даатгалын байгууллагад тухай бүр мэдэгдэх үүрэгтэй.

## **26 дугаар зүйл.Тэтгэврээс суутгал хийх**

26.1.Тэтгэврээс дараах үндэслэлээр суутгал хийнэ:

26.1.1.хуурамч баримт бичиг бүрдүүлсний улмаас үндэслэлгүйгээр тэтгэвэр авсан нь нийгмийн даатгалын болон мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн актаар тогтоогдсон бол;

26.1.2.тэтгэвэр авагч энэ хуулийн 25.3-т заасан үүргээ биелүүлээгүйгээс тэтгэвэр илүү авсан нь нийгмийн даатгалын болон мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн актаар тогтоогдсон бол.

26.2.Тэтгэврээс нэг удаа суутгах суутгалын хэмжээ нь тэтгэвэр авагчийн нэг сарын тэтгэврийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.

26.3.Энэ зүйлд зааснаас бусад тохиолдолд тэтгэврээс суутгал хийх, тэтгэврийг барьцаалахыг хориглоно.

## **27 дугаар зүйл.Тэтгэврийн хэмжээг индексжүүлэх**

27.1.Инфляцийн жилийн түвшин 4 ба түүнээс дээш хувь болох тохиолдолд тэтгэврийн хэмжээг дараа онд багтаан хэрэглээний үнийн өөрчлөлтийн хэмжээгээр индексжүүлнэ.

27.2.Инфляцийн жилийн түвшин 4 хувьд хүрэхгүй байснаас үүдэн тэтгэврийн хэмжээг 3 жил дараалан индексжүүлээгүй бол өмнөх онуудын хэрэглээний үнийн өөрчлөлтөд үндэслэн заавал индексжүүлнэ.

27.3.Энэ зүйлийн 27.1, 27.2-т заасан индексийн хэмжээг Засгийн газар тогтооно.

27.4.Тэтгэврийн хэмжээг индексжүүлэхэд шаардагдах хөрөнгийг нийгмийн даатгалын сангийн болон улсын төсөвт жил бүр тусгана.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **28 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

28.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.2.Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль, эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

### **29 дүгээр зүйл.Хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт**

29.1.Энэ хууль хүчин төгөлдөр мөрдөхөөс өмнө өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, энэ хуулийн 7.1.1-д заасан насанд хүрсэн тэтгэвэр авагчид суурь тэтгэвэр олгоно.

29.2.Энэ хуулийн 7.1.5 дахь заалт нь 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

29.3.Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө тогтоосон тэтгэврийг энэ хуулийн 25.1-д зааснаас бусад тохиолдолд өөрчлөн тогтоохгүй.

### **30 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

30.1.Энэ хуулийг 20. . . оны ... дугаар сарын .. -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ